

БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ
ТУХАЙ ГЭРЭЭ

2018 он 07 сарын 01.өдөр

Дугаар 008.

Алтай сум

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 2.4, 3.1.3, 6.1.3-т заасны дагуу нэг талаас Говь-Алтай аймаг /хот/-ийн Алтай сум ,\дүүрэг \-ын Засаг дарга Д.Цэрэвсамбуу цаашид “Засаг дарга” гэх/, нөгөө талаас “Баяндэлгэрэх” нөхөрлөл, хоршоо , бүртгэгдээгүй нөхөрлөл (цаашид “ Бичил уурхай эрхлэгч этгээд” гэх)-ийг төлөөлж дарга (албан тушаал С.Эрдэнэсүрэн нар \цаашид хамтад нь “талууд”гэх\ дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2018оны 07дугаар сарын 01-ны өдөр энэхүү гэрээг \цаашид “ гэрээ” гэх Алтай сум \дүүрэг\ -д байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь Алтай сум \дүүрэг\ -ий “Торготын нурууны замын ам” нэртэй газарт орших 5га гектар талбайд журмын 6.1.3-т заасны дагуу 03.сарын хугацаагаар алт (ашигт малтмалын төрөл) олборлохтой холбогдсон үйл ажиллагаа эрхэлнэ.

1.2.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум (дүүрэг)-ийн Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

Хоёр. Сум (дүүрэг)-ийн Засаг даргын эрх, үүрэг

2.1. Сум (дүүрэг)-ийн Засаг дарга нь “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. Бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжээг тогтоож, байршлын зургийг гэрээнд хавсаргах.

2.1.2. Хог хаягдлын цэгийн байршлыг тогтоох

2.1.3. Бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах талбайг тогтоох.

2.1.4. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг тооцож, бичил уурхай эрхлэгч этгээдтэй тохиролцсоны үндсэн дээр зохих хөрөнгийг төвлөрүүлэх.

2.1.5. Бичил уурхайн ажилтнуудад \цаашид “ажилтан” гэх. \ зориулсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах.

2.1.6. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах.

2.1.7. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих

2.1.8. Хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох.

Гурав. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

3.1. Бичил уурхай эрхлэгч этгээд дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. Бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах.

3.1.2. Ажилтнуудыг тогтоосон талбайд суурьшуулах

3.1.3 суурьшлын талбайг тохижуулах, ахуйн болон үйлдвэрийн хог, хаягдлын цэгийг байгуулах.

- 3.1.4. Гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүн бус этгээдийг ажиллуулахгүй байх.
- 3.1.5. Байгаль орчныг хамгаалж, гол горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх.
- 3.1.6. Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.
- 3.1.7. Хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтнуудад сургалт, сурталчилгаанд бичил уурхайчдыг идэвхтэй оролцуулах.
- 3.1.8. Ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбайд гүйцэтгэх.
- 3.1.9. Үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглахгүй байх.
- 3.1.10. Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500м3 хүртэлх багтаамжтай дотоод шаталтаг хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах.
- 3.1.11. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд нэг сар тутамд шаардагдах 1000000.᠕ нэг сая төгрөгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх.
- 3.1.12. Нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах.
- 3.1.13. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу олборлолт явуулсан талбайдаа нөхөн сэргээлт хийж сум дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэж өгөх.
- 3.1.14. ХХОАТ нөхөрлөл нэг сард 300000 \ Гурван зуун мянган\ төгрөг төлнө. Ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар төлөх.
- 3.1.15. Олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээдэд худалдах.

Дөрөв. Харилцан хүлээх үүрэг

- 4.1 Гэрээнд талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуурлан хамтарч ажиллана.
- 4.2. Гэрээний дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох явцад байгаль орчин бусад этгээдэд хохирол учруулсан тохиолдолд бичил уурхай эрхлэгч этгээд уг хохирлыг барагдуулах үүрэгтэй.
- Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчинд учруулсан хохирлыг арилгуулахыг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардана.
- 4.3. Талууд энэхүү гэрээний биелэлтийг жил бүр хамтран дүгнэж, аймаг (нийслэл)-ийн Засаг даргад дараа оны 1 дүгээр сард багтаан тайлагнана.

Тав. Маргаан шийдвэрлэх.

- 5.1. Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

5.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

Зургаа. Гэрээний хүчин төгөлдөр болох.

6.1. Энэхүү гэрээ нь 2018 оны 07 сарын 01-ны өдрөөс 2018 оны 10 сарын 01-ны өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.2. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах.

7.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

7.2. Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

7.3. Энэхүү гэрээ нь 2018 онысарын өдрөөс 2018 онысарынөдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.4. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээг сунгаж болно.

20.....онысарынөдрөөс 20..... онысарынөдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

20.....онысарынөдрөөс 20..... онысарынөдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

20.....онысарынөдрөөс 20..... онысарынөдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

20.....онысарынөдрөөс 20..... онысарынөдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА

АЛТАЙН БИЧИЛ УУРХАЙЧДЫН ЭВ

Д.ЦЭРЭВСАМБУУ

НЭГДЛИЙН ХОЛБООНЫ ТЭРГҮҮН

Д.ЦЭРЭВСАМБУУ

С.МЯДАГБАДАМ Ч.МЯДАГБАДАМ

УТАСНЫ ДУГААР *99975815*

УТАСНЫ ДУГААР *89976063*

"*Баянгол*" НӨХӨРЛӨЛИЙН АХЛАГЧ: *С. ДУГААР*